

ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ

Чех хэлний шалгалтад бэлдэгч танаа,

энэхүү анхааруулга нь хувийн мэдээллийг боловсруулахтай холбогдон хувь хүнийг хамгаалах болон эдгээр мэдээллийн чөлөөт хөдөлгөөний тухай (цаашид: Хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журам, **GDPR** гэх) Европын Парламент ба зөвлөлийн (ЕХ) 2016/679-р журмын 13 дугаар зүйлийн дагуу Бүгд Найрамдах Чех Улсын Сурган хүмүүжүүлэх үндэсний хүрээлэнгээс Таны хувийн мэдээллийг боловсруулах цар хүрээ болон арга хэлбэрийн талаар мэдээлэх үүргийг гүйцэтгэнэ.

I.

Хянан зохицуулагч

1. Хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журмын 7 дугаар хэсгийн 7. 4 дүгээр зүйлийн дагуу хувийн мэдээлэл хянан зохицуулагчаар **Бүгд Найрамдах Чех Улсын Сурган хүмүүжүүлэх үндэсний хүрээлэн (сурган хүмүүжүүлэх ажилтнуудын цаашдын боловсролд зориулсан байгууллага)**, Улсын бүртгэлийн дугаар: 45768455 (цаашид зөвхөн: „хянан зохицуулагч“).
Хянан зохицуулагчтай холбоо барих
хаяг: Senovážné náměstí 872/25, 110 00, Praha 1
и-мэйл: sekretariat@npicr.cz
утас: +420 222 122 112
2. Хувийн мэдээлэл гэж тодорхойлогдох буюу тодорхойлогдохуйц хувь хүнд хамааралтай аливаа мэдээллийг хэлнэ; тодорхойлогдохуйц хувь хүн гэдэг нь шууд болон шууд бус байдлаар, ялангуяа тодорхой шинж тэмдгээр, тухайлбал нэр, таних дугаар, байршлын мэдээлэл, сүлжээний таних тэмдэг эсвэл тухайн хүний бие махбод, физиологи, удамшил, сэтгэл зүй, эдийн засаг, соёл, нийгмийн шинж чанаруудын нэг буюу хэд хэдэн онцгой хүчин зүйлээр тодорхойлж болох хувь хүн юм.
3. Хянан зохицуулагч нь хувийн мэдээлэл хамгаалах ажилтныг томилсон. Ажилтантай холбоо барих: Док., Инженер Лубош Сыхра, и-мэйл: gdpr@msmt.cz, утас: 234 814 303.

II.

Боловсруулсан хувийн мэдээллийн эх сурвалж ба ангилал

1. Боловсрол, залуучууд ба биеийн тамирын яаманд бүртгэлтэй, чех хэлний мэдлэг шалгах эрх бүхий шалгалт авах байгууллагад (биечлэн эсвэл онлайн маягыг ашиглан) Таны өгсөн хувийн мэдээллийг хянан зохицуулагч боловсруулдаг. Шалгалт авах байгууллага Таны хувийн мэдээллийг хянан зохицуулагчид шилжүүлэн өгдөг.

2. Хянан зохицуулагч доорх хувийн мэдээллийг боловсруулдаг:
 - i. овог, нэр, гадаад паспортын дугаар, хүйс, улсын харьяалал, төрсөн он сар өдөр, Гэрчилгээ илгээх хаяг, утасны дугаар, и-мэйл, хувийн мэдээллийн хайрцаг
 - ii. чех хэлний шалгалттай холбоотой мэдээлэл (шалгалтын тов, шалгалт болох газар, хэд дэх удаа өгч байгаа, шалгалтын дүн, тусгай хэрэгцээний мэдээлэл, ДЯ-ны дахин шалгалтын тухай мэдээлэл, дахин шалгалтын үндсэн дугаар)

III.

Хувийн мэдээллийг боловсруулах эрх зүйн үндэслэл ба зорилго

1. Хувийн мэдээллийг боловсруулах эрх зүйн үндэслэл нь:

Журмын 6 дугаар зүйлийн 6. 1 д) хэсэгт заасны дагуу томилогдсон хянан зохицуулагч нь олон нийтийн ашиг сонирхол эсвэл төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг биелүүлэхэд боловсруулалт зайлшгүй шаардлагатай юм.
2. Хувийн мэдээллийг боловсруулах зорилго нь:
 - Бүгд Найрамдах Чех Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суух зөвшөөрөл авах зорилгоор чех хэлний мэдлэгийг нотлох шалгалтыг амжилттай өгсөн тохиолдолд Гэрчилгээ олгоно
 - өргөдөл гаргагчийн бүртгэлийн дугаарыг үүсгэх
 - статистик үнэлгээ гаргах
 - Орогнох эрх болон шилжин суурьших хөдөлгөөний бодлогын хэлтсийн ажилтнууд шалгалт өгөгчийн биеийн байцаалтыг шалгах
3. Хянан зохицуулагчийн зүгээс Хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журмын 22 дугаар зүйлд зааснаар бие даан автоматжуулсан шийдвэр гаргахгүй.

IV.

Мэдээлэл хадгалах хугацаа

1. Хянан зохицуулагч нь хувийн мэдээллийг 5 жил хадгална.
2. Хувийн мэдээлэл хадгалах хугацаа дуусахад хянан зохицуулагч хувийн мэдээллийг тодорхой бус болгоно.

V.

Хувийн мэдээллийг хүлээн авагч

1. Чех хэлний шалгалт авах эрх бүхий хуулийн этгээд буюу шалгалт авах байгууллага нь Гадаадын иргэд байнга оршин суух тухай 1999/326 тоот хуулийн 180з дүгээр зүйлийн 180з. 2-т заасны дагуу шалгалтад бүртгэх зорилгоор өргөдөл гаргагчийн хувийн мэдээллийг авна.

VI.

Таны эрх

1. Хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журамд заасан нөхцөлийн дагуу Та:
 - i. Хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журмын 15 дугаар зүйлийн дагуу өөрийн хувийн мэдээлэлд нэвтрэх,
 - ii. Хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журмын 16 дугаар зүйлийн дагуу хувийн мэдээллийг засах эсвэл Хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журмын 18 дугаар зүйлийн дагуу боловсруулалтад хязгаарлалт хийх,
 - iii. Хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журмын 17 дугаар зүйлд заасны дагуу хувийн мэдээллийг устгах,
 - iv. Хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журмын 21 дүгээр зүйлийн дагуу боловсруулалтаас татгалзах болон
 - v. Хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журмын 20 дугаар зүйлийн дагуу мэдээллийг зөөвөрлөх эрхтэй.

2. Үүнээс гадна Таны хувийн мэдээллийг хамгаалах эрхийг зөрчсөн гэж үзвэл Та Хувийн мэдээлэл хамгаалах алба (цаашид зөвхөн: "Алба")-нд гомдол гаргах эрхтэй.
Албатай холбоо барих:
хаяг: Pplk. Sochora 27, 170 00 Praha 7
суурин утас: +420 234 665 111 (төв утас)

VII.

Хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцөл

1. Хянан зохицуулагч нь хувийн мэдээллийг хамгаалахын тулд техникийн болон зохион байгуулалтын зохих бүх арга хэмжээг авснаа мэдэгдэж байна.
2. Хянан зохицуулагч нь мэдээллийн санг хамгаалахын тулд техникийн арга хэмжээг авсан.
3. Хянан зохицуулагч нь зөвхөн эрх бүхий хүмүүс хувийн мэдээлэлд нэвтрэх эрхтэй гэдгийг мэдэгдэж байна.

VIII.

Төгсгөлийн заалт

1. Та хувийн мэдээллээ шалгалт авах байгууллагад өгснөөр (өргөдөлд гарын үсэг зурах эсвэл онлайн маягтын хувийн мэдээлэл боловсруулах тухай мэдээлэлтэй танилцсан нүдийг бөглөснөөр) хувийн мэдээлэл хамгаалах нөхцөлтэй танилцсан гэдгээ баталж байна.